



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Сэрвэй сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 нэрийн нийт 222,883,897.68 (хоёр зуун хорин хоёр сая найман зуун наян гурван мянга найман зуун ерэн долоон төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 63,020,628.76 / жаран гурван сая хорин мянга зургаан зуун хорин найман төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Бурмаа, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын дарга Л.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Хүлээн авсан үл хөдлөх хөрөнгийн доорх газар эзэмших эрхийг шилжүүлэн баталгаажуулах;

2.4. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05 ны өдрийн хурлын
27 дугаар тогтоолын хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭРВЭЙ СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТЦЭЛТЭЙ
ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛАЙН ГАЗАРТ
ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тэжээлийн фонд /чулуун барилга/	1972.07.13	ш	1	150,206,815.25	12,517,234.56	137,689,580.69
2	10 тн пүүний барилга /модон/	1972.07.01	ш	1	353,082.43	117,694.20	235,388.23
3	Өвсний сараа /модон/	1972.07.01	ш	1	72,324,000.00	50,385,700.00	21,938,300.00
Нийт дүн					222,883,897.68	63,020,628.76	159,863,268.92
					/хоёр зуун хорин хоёр сая найман зуун наян гурван мянга найман зуун ерэн долоон төгрөг жаран найман мөнгө/	/жаран гурван сая хорин мянга зургаан зуун хорин найман төгрөг далан зургаан мөнгө/	/нэг зуун тавин есөн сая найман зуун жаран гурван мянга хоёр зуун жаран найман төгрөг ерэн хоёр мөнгө/